

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023.оны
12..... дугаар сарын 27.....-ны өдрийн 8/нон
дугаар тушаалтын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
 шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27 8/нон

Байгууллагын нэр:

Мөрдөн байцаах алба

Албан тушаалын нэр:

Шинжээч – ахлах мөрдөгч

Ажлын цаг:

8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Хүнд гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-4

Ажлын байрны албан ёсны байршил:

Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо,
Самбуугийн гудамж 18

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд уртасгасан цагаар болон өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах, нэгжүүдийн мөрдөгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах, цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг, Экологийн цагдаагийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд тусгай мэдлэгийн хүрээнд экологийн шинжилгээ хийж /баталгаажуулах, зөвлөх үйл ажиллагаа/ магадлагаа гаргах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, илрүүлэх, шийдвэрлэх ажлыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх,

-Улсын ерөнхий прокурорын газраас харьялалт тогтоосон, Экологийн цагдаагийн албанаас илрүүлсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах.

Албан тушаалын зорилт:

- 1.Харьялах гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах, ажлын хэсэгт ажиллах;
- 2.Хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаанд ач холбогдол бүхий байдлыг тогтоох зорилгоор шинжилгээ хийж /баталгаажуулах, зөвлөх үйл ажиллагаа/ магадлагаа гаргах;
- 3.Мөрдөн шалгах ажиллагаанд тусгай мэдлэгийн хүрээнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 4.Гэмт хэрэгтэй тэмцэх ажилд хүндрэл учруулж буй шалтгаан нөхцөлийг арилгах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр санал, санаачилга гаргах;
- 5.Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, илрүүлэх чиглэлээр алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тусгай мэдлэгийн хүрээнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 6.Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах -Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1.Эрүүгийн хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны холбогдох журамд заасныг хэрэгжүүлэх;</p> <p>1.2.Цагдаагийн ерөнхий газар, албаны даргын тушаалаар баталсан дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлж ажиллах;</p> <p>1.3.Гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрэн сурвалжлах, олж тогтоох.</p> <p>1.4.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяаллын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах.</p>	Мөрдөн шалгах ажлын үр дүн дээшилж, гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт ахисан байна.	Г Г Г Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Мөрдөгч, прокурор, шүүгчээс ирүүлсэн даалгавар, тогтоолын дагуу тавьсан асуултад тусгай мэдлэгийн хүрээнд хариулж, магадлагаа гаргах;</p> <p>2.2.Үйл ажиллагаандаа хуулийг дээдэлж, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллах;</p> <p>2.3.Гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, шаардлагатай бүртгэл судалгаа, мэдээллийн санг бүрдүүлж, дүн шинжилгээнд ашиглах болон бүс, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион явуулах.</p>	Гэмт хэрэг, зөрчил шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.	Г Г Г,Х

3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Хэргийн газрын үзлэг хийж байгаа алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, тусгай мэдлэгийн хүрээнд хяналт тавьж, холбогдох стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах; 3.3.Удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгавар, холбогдох байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийг цаг тухайд нь биелүүлж, хариу мэдэгдэх.	Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд ахиц гарна.	Г,Х Г
4 дугаар зорилтын хүрээнд	4.1.Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд учирч буй хүндрэл бэрхшээлийг арилгах, боловсронгуй болгох чиглэлээр санал, санаачилга гаргаж, удирдлагад танилцуулах; 4.2.Цагдаагийн байгууллагын нийтлэг үүргийн хүрээнд холбогдох албадыг мэдээ, мэдээллээр зохих журмын дагуу хангах; 4.3.Ажлаа долоо хоногоор төлөвлөн, өдөр тутмын тэмдэглэл хөтөлж, сар, улирал, жилээр хийсэн ажлын талаарх мэдээг хүснэгт болон бичмэлээр гаргаж, ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүгнүүлнэ.	Хууль, эрх зүйн хийдэл арилж ажлын үр дүн сайжирна.	Г, Х Г Г
5 дугаар зорилтын хүрээнд	5.1.Нэгжээс зохион байгуулсан иргэд, олон нийтэд хандсан олон талт ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; 5.3.Албаны бүтцийн нэгжийн алба хаагчдад тусгай мэдлэгийн хүрээнд сургалт зохион байгуулах.	Ажлын үр дүн, алба хаагчдын хуульч ажиллагаа дээшилнэ.	Г,Х Г,Х
6 дугаар зорилтын хүрээнд	6.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх; 6.2.Авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, шударга ёсыг эрхэмлэн, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд мөрдөх; 6.3.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэх ажиллах.	Хуулийн хэрэгжилт хангагдан, үр нөлөө дээшилнэ.	Г Г Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	-Эрх зүй /0421/ -Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.

Туршлага	Цагдаагийн байгууллагад 6-аас доошгүй жил, үүнээс нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын офицер албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх; -Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг дүгнэх; -Мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; -Нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; -Судалгааны арга зүйн мэдлэгтэй.	
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах, -Асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; -Удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах; -Албан үүргийнхээ дагуу хариуцуулах ажил үүргийн хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх.	
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонгой хуваалцаж хамтран ажиллах; -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.	
	Бусад	-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх; -Компьютерын Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх; -Газрын зургийн GIS, Autocad зэрэг программуудыг эзэмшсэн байх; -Экологи, эдийн засгийн үнэлгээ хийж сурсан байх, нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах программ хангамж дээр ажилладаг байх. -Нууц хадгалах.	

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Хүнд гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

Шууд харилцах байгууллага:

-Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;


Шууд бус харилцах байгууллага:

-Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдо заалтыг баримтална/.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

<p>Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА</p> <p></p> <p>Т.ГАНЗОРИГ</p> <p>2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр</p>	<p>Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:</p>
---	--

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-өдөр
Дугаар: 101

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

ТАНИЛЦСАН:

<p>Албан тушаалтан:</p> <p>.....</p> <p>.....</p>

20.... оны дугаар сарын-ны өдөр